

“Кандодена” ХЗХ-ын хадгаламж, зээлийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.4, 13.1, Хорооны 52 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооний тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 3 дугаар хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг зөрчсөн “Кандодена” ХЗХ-ын хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, авсан арга хэмжээний талаарх тайланг Хороонд ирүүлэхийг “Кандодена” ХЗХ /Ц.Алтанцэцэг/-нд үүрэг болгосугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ